



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



## “ШИЛДЭГ ТоС-БАНК” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

### **Нэг. Үндсэн мэдээлэл, зорилго**

Жил бүр уламжлал болгон шалгаруулдаг “Шилдэг ТоС-Банк” уралдааныг Монгол Улсад банкны салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан “Банкны Хөгжил-95 жил” аяны хүрээнд Монголбанк, Монголын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн Холбоо хамтран нийт 15 банкны дунд зохион байгуулж байна.

Энэхүү уралдааны зорилго нь Монгол Улсын Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг, Засгийн газрын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлд заасны дагуу ТоС хөтөлбөрийн хүрээнд банкуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, байгаль орчин, нийгэмд ээлтэй олон улсад мөрдөж буй тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг санхүүгийн системд нэвтрүүлэхэд оршино.

### **Хоёр. Хугацаа**

Уралдааныг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал зохион байгуулна.

### **Гурав. Шалгаруулалт**

Шалгаруулалт дөрөвдүгээр заалтны үндсэн 4 төрөлд явагдах бөгөөд банкнууд өөрсдийн мэдээллийг дээрх шаардлагын дагуу үнэлэн тайлагнаж, баталгаажуулан, видео тайланг 2019 оны 11 дүгээр сарын 06-ний дотор [communication@mongolbank.mn](mailto:communication@mongolbank.mn), [info@toc.mn](mailto:info@toc.mn) хаягаар ирүүлнэ.

Сонгон шалгаруулалтыг хараат бус мэргэжлийн хороо тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж, газар дээр үзлэг хийн 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр шалгаруулна.

### **Шагнал:**

Шалгуурын төрөл тус бүрт шалгарсан банкинд батламж олгож, шилдгээр шалгарсан банкинд “Шилдэг ТоС Банк” шилжин явах цом, Монголбанкны нэрэмжит батламж, дурсгалын зүйл олгоно.

Шалгарсан банкнуудын видео тайланг Монголбанк, ТоС Холбооны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

**Дөрөв. Шалгаруулах үндэслэл (Шалгуур үзүүлэлт):**

<b>Шаардлага</b>	<b>Оноо</b>
<b>1. ТоС-ийн хэрэгжилт</b>	<b>30</b>
<i>ТоС-ийн тусгайлсан бодлого, журам баталсан эсэх</i> <i>Бодлого, журамд ТоС-ийн 8 зарчимтай холбоотой асуудлуудыг тусгасан байдал</i> <i>ТоС-ийг харцуцсан ажилтантай эсэх</i> <i>Бодлого, журмын хэрэгжилт /харилцагч ажилтнууддаа таниулах, холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах гэх мэт./</i> <i>Банкны тогтвортой санхүүжилтийн бодлогын хэрэгжилтийг хянах мөн дотоод, гадаад тайлагналын механизмтай эсэх</i>	
<b>2. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын систем</b>	<b>35</b>
<i>ТоС-ийн босго буюу 50 сая, 12 сарын хугацаатай бизнесийн зээлд БОН-ийн үнэлгээ хийдэг байдал</i> <i>БОН-ийн эрсдэлтэй холбоотой асуудал зээлийн процесст тусгагдсан байдал</i> <i>БОН-ийн эрсдэлийн үнэлгээ хийсэн зээлийн тоо/дүн</i> <i>Зээлийн эргэн хяналтаар БОН-ийн асуудлуудыг шалгаж буй эсэх, тайлан авч буй эсэх</i> <i>Эрсдэлийн үнэлгээнд ТоС-тэй холбоотой шаардлагуудыг тусгасан байдал</i> <i>Хориглосон болон анхаарах үйл ажиллагааны жагсаалтыг хэрэгжүүлж буй эсэх</i> <i>Ногоон бүтээгдэхүүн/үйлчилгээний төрлүүд, зээл олгосон байдал /тоо, дүн/</i>	
<b>3. ТоС-ийн дэмжлэгийн тогтолцоо</b>	<b>15</b>
<i>Банкны удирдлагуудын ТоС-ийн сургалтад хамрагдсан байдал</i> <i>Банкны ажилтнуудын ТоС-ийн сургалтад хамрагдсан байдал</i> <i>ТоС-ийн ажлуудтай холбоотой шийдвэр гаргалт, удирдлагын тогтолцоог тодорхой болгосон байдал</i>	
<b>4. ТоС Оффис</b>	<b>20</b>
<i>Хогны менежментийг хэвшүүлсэн байдал (хогоо ялгаж, дахин хэрэглэж, хог дахин боловсруулах цэгт тушаах г.м)</i> <i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчинг бүрдүүлсэн байдал (лифт, налуу зам, дуут вебсайт г.м)</i> <i>Нөөцийн хэмнэлт+ТоС бүтээлч санаачлага (тог, цаас хэмнэх, хувцас хандивлах г.м)</i> <i>Ногоон байгууламжийн хэмжээ</i> <i>Нийгмийн харцуцлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлдэг эсэх</i>	
<b>Нийт</b>	<b>100</b>

**ТоС ХОЛБОО, МОНГОЛБАНК**  
Дэлгэрэнгүй мэдээллийг  
11-323581, 11-310117 утсаар лавлана уу.